



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛТ**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
<http://www.parliament.mn>

2024.03.01 № 07

Г Асуулт тавих тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.2-т ““Элэг бүтэн Монгол” арга хэмжээний үр ашиг, өгөөж, хуртээмжийг нэмэгдүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэн” гэж, мөн Монгол улсын 2023 оны улсын төсвийн Эрүүл мэндийн сайдын багцад “Элэгний Б, Д вирустай иргэдийн эмчилгээнд зарцуулах”-аар 13,5 тэрбум төгрөгийг төсөвлөсөн.

Уг төсвийн хөрөнгөөр элэгний Б, Д вирусын эмчилгээнд ашиглах зориулалтаар өндөр гаж нөлөө үзүүлдэг, эмчилгээний үр дүн бага Пегинтерферон Альфа2 тариаг худалдан авахаар тендер зарлаж, сонгон шалгаруулалтыг явуулсан байна. Эрүүл мэндийн яамнаас олон нийтэд хүргэсэн мэдээллээс үзэхэд “ДЭМБ-ын зааварт байгаа гэх тайлбар” нь тухайн тарилгыг худалдан авах шийдвэрийг зөвтгөх шалгаан биш юм.


Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт тус тус заасныг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1. ““Элэг бүтэн Монгол” арга хэмжээний хүрээнд элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 50-иас дээш хувийг эмчилгээнд хамруулах, хорт хавдрын эрх илрүүлгийг олон улсын жишигт хүргэх ажлын явцын талаар;
2. Монгол Улсын 2023 оны төсвийн Эрүүл мэндийн сайдын багцад “Элэгний Б, Д вирустай иргэдийн эмчилгээнд зарцуулах”-аар төсөвлөгдсөн 13,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэл, зарцуулалтын болон ажлын явцын талаар;
3. Монгол Улсад элэгний Б, Д вирусын эмчилгээнд ашиглаж байгаа Пегинтерферон Альфа2 тарилгын гаж нөлөө, үр дүнгийн талаарх судалгаа, тоо баримтыг ирүүлэх.

Энэхүү асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэх бөгөөд мөн зүйлийн 12.4 дэх хэсэгт заасны дагуу Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулах болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ж.ЧИНБҮРЭН

2024000011